



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/03/-НА-СТА-ААТҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: <a href="mailto:gerleen1111@gmail.com">gerleen1111@gmail.com</a></p>
---	---


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	
3.8 Аудитын гол асуудал .....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15

№

171

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланд НӨАТ-ын өглөгийг 4.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, НӨАТ-ын тайланд борлуулалтын орлогыг 0.79 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй ажилчдыг амрахад зориулж төсвөөс 0.34 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан, 1.0 сая төгрөгийн тавилга бэлтгэсэн зэрэг нийт 6.5 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн

07120074

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ  
АУДИТОР


Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,546,694.76</b>	<b>24,292,159.95</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>132,694.76</b>	<b>998,128.43</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>132,694.76</b>	<b>998,128.43</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>132,694.76</b>	<b>998,128.43</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	132,694.76	998,128.43
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>2,439,687.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	2,439,687.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>12,414,000.00</b>	<b>20,854,344.52</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,414,000.00</b>	<b>20,854,344.52</b>
35420	Аж ахуйн материал	12,414,000.00	20,854,344.52
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>122,789,655.00</b>	<b>118,377,653.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>122,789,655.00</b>	<b>118,377,653.00</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>102,789,655.00</b>	<b>96,472,653.00</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	150,570,644.00	149,137,044.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,134,189.00	-59,338,791.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,956,100.00	24,956,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,956,100.00	-24,956,100.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	71,358,553.00	65,352,132.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,607,353.00	-61,738,732.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,298,495.00	4,628,306.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,696,495.00	-1,567,306.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	576,610.00	337,580.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-576,610.00	-337,580.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>20,000,000.00</b>	<b>21,905,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	21,905,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>135,336,349.76</b>	<b>142,669,812.95</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,825,812.98</b>	<b>38,316,499.98</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,825,812.98</b>	<b>38,316,499.98</b>
<b>41200</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>0.00</b>	<b>15,000,000.00</b>
<b>41210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>15,000,000.00</b>
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	0.00	15,000,000.00
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>5,825,812.98</b>	<b>23,316,499.98</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	326,251.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>5,825,812.98</b>	<b>22,990,248.98</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	5,825,812.98	13,960,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1,100,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	7,930,248.98
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>129,510,536.78</b>	<b>104,353,312.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>129,510,536.78</b>	<b>104,353,312.97</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,951,759.81	126,951,759.81
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,558,776.97</b>	<b>-22,598,446.84</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	713,776.97	2,558,776.97
51220	Тайлант үеийн үр дүн	1,845,000.00	-25,157,223.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>135,336,349.76</b>	<b>142,669,812.95</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,933,980.22	7,014,522.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,933,980.22	7,014,522.70
120	Нийтлэг татварын бус орлого	27,933,980.22	7,014,522.70
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	182,429,715.38	190,274,792.73
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	154,495,735.16	183,260,270.03
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,088,980.22	32,171,746.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,088,980.22	32,171,746.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,088,980.22	32,171,746.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,883,980.22	32,171,746.51
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	25,609,951.00	25,609,000.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	0.00	312,374.51
210813	Бусад зардал /ТӨҮГ/	274,029.22	6,250,372.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	205,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,845,000.00	-25,157,223.81
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,845,000.00	-25,157,223.81

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,951,759.81	713,776.97	127,665,536.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,951,759.81	713,776.97	127,665,536.78
9	Тайлант үеийн үр дүн	0.00	1,845,000.00	1,845,000.00
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,951,759.81	2,558,776.97	129,510,536.78
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	126,951,759.81	2,558,776.97	129,510,536.78
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,951,759.81	2,558,776.97	129,510,536.78
19	Тайлант үеийн үр дүн	0.00	-25,157,223.81	-25,157,223.81
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	126,951,759.81	-22,598,446.84	104,353,312.97

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	200,672,686.92	209,302,272.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,672,686.92	209,302,272.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,672,686.92	209,302,272.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	200,405,452.00	209,302,272.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,389,690.94	219,331,838.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,389,690.94	219,331,838.33

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>189,389,690.94</b>	<b>219,331,838.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>52,545,120.00</b>	<b>63,414,025.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	52,545,120.00	63,414,025.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,328,511.00</b>	<b>23,240,401.58</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	20,328,511.00	23,240,401.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,531,322.00</b>	<b>20,427,447.84</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	13,531,322.00	20,427,447.84
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>82,231,440.00</b>	<b>91,184,885.00</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	78,408,540.00	10,100,585.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	3,822,900.00	81,084,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,753,297.94</b>	<b>21,065,078.91</b>
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	274,029.22	312,374.51
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	10,103,603.72	6,706,030.40
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	127,925.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	10,247,740.00	14,046,674.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>11,282,995.98</b>	<b>-10,029,566.33</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,190,000.00</b>	<b>4,105,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,190,000.00</b>	<b>4,105,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,190,000.00</b>	<b>4,105,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,190,000.00	4,105,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,190,000.00</b>	<b>-4,105,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-9,000,000.00</b>	<b>15,000,000.00</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>0.00</b>	<b>25,000,000.00</b>
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	25,000,000.00
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>9,000,000.00</b>	<b>10,000,000.00</b>
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	9,000,000.00	10,000,000.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>92,995.98</b>	<b>865,433.67</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,698.78	132,694.76
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,694.76	998,128.43

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажиллагааны орлого	187,576,000.0	190,274,792.73	(2,698,792.7)	<b>101%</b>
Бусад орлого	560,000.0	-	560,000.0	<b>0%</b>
<b>ОРЛОГО</b>	<b>188,136,000.0</b>	<b>190,274,792.7</b>	<b>(2,138,792.7)</b>	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	156,759,500.00	181,600,583.03	(24,841,083.0)	<b>116%</b>
<b>1.3 Нийт ашиг</b>	<b>31,376,500.00</b>	<b>8,674,209.70</b>	<b>22,702,290.30</b>	<b>28%</b>
Удирдлага борлуулалтын зардал	25,609,000.0	25,609,000.00	-	<b>100%</b>
Хүүгийн зардал	1,386,000.0	312,374.51	1,073,625.5	<b>23%</b>
Бусад	2,500,000.0	7,910,059.00	(5,410,059.0)	<b>316%</b>

1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	29,495,000.00	33,831,433.51	4,336,433.51	-	115%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	1,881,500.00	25,157,223.81	27,038,723.81	-	-1337%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	1,881,500.00	25,157,223.81	27,038,723.81	-	-1337%
Татвар төлөх ашиг алдагдал	1,881,500.00	25,157,223.81	27,038,723.81	-	13.37
3.1 Орлогын татварын зардал	188,100.00		188,100.0		
4. Татварын дараах ашиг алдагдал	1,693,400.00	25,157,223.81	26,850,623.81	-	13.37

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад байгууллагын үйл ажиллагааг зөв зохистой удирдан ашигтай ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл нь уур үйлдвэрлэл, халуун ус хангамжийн үйл ажиллагааг эрхлэн явуулна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 189.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 215.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

#### **Байгууллагын үйл ажиллагаа**

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зорилго нь холбогдох үйлчилгээний чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулж харьяалах нутаг дэвсгэртээ үйлчилгээнийхээ хүрээг тэлж хэрэглэгчдийг норм, стандартын шаардлагад нийцсэн жигд найдвартай үйлчилгээгээр хангаж үр ашигтай ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг холбогдох хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн хэмжээнд өөрийн үйлдвэрийн газрын чиглэл тус бүрээр үйл ажиллагааг явуулж, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлээр байнга тасралтгүй хангах, чанарын хяналт тавих гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

#### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2019 оны 56 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай 35 дугаар зүйлд "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх: ... 35.1.12.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан

буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн эрхийг орон нутагт тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлэхээр заасан.

Иймд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийн эрхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хэрэгжүүлж байгаа бөгөөд цалин, урамшуулал олгоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тодорхой ажил хийхээр тусгагдаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардалгүй ажиллаж, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

### 3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	132.7	998.1	864.4
БХХО			
Авлага	0	2,439.7	2,439.7
Урьдчилгаа			
Бараа материал	12,414.0	20,854.3	8,440.3
Үндсэн хөрөнгө	251,760.4	244,411.2	-7,349.2
Биет бус хөрөнгө	20,000.0	21,905.0	1,905.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>135,336.3</b>	<b>142,669.8</b>	<b>7,333.5</b>
Өр төлбөрийн дүн	5,825.8	38,316.5	32,490.7

Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	129,510.5	104,353.3	-25,157.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>135,336.3</b>	<b>142,669.8</b>	<b>7,333.5</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 1.0 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ажиллагсдаас авах авлага 0.78 сая төгрөг, хувь хүнээс авах авлага 1.7 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд ажиллагсдаас авах цалингийн урьдчилгааны хүрээнд үүссэн авлага 0.78 сая төгрөгөөр нэмэгдсэн, харилцагчид нүүрсний үнийг илүү шилжүүлснээс үүссэн 1.7 сая төгрөгийн авлагууд нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 2.4 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20.9 сая төгрөг болж 8.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 90.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 82.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 4.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр 10.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгөөс аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 16 дугаар тогтоолоор нийт 9.1 сая төгрөгийн өртөгтэй, 9.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 24 ширхэг хөрөнгийг акталсан байна. Мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 20 дугаар тогтоолоор нийт 0.23 сая төгрөгийн өртөгтэй 0.23 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 15 нэр төрлийн хөрөнгийг, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 97 дугаар тогтоолоор тогтоолоор нийт 0.81 сая төгрөгийн өртөгтэй 0.81 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1 нэр төрлийн хөрөнгийг тус тус акталсан байна.

Биет бус хөрөнгө 1.9 сая төгрөгөөр өссөн нь халаалтын зуухны зураг төсөв, 0.28 сая төгрөгийн кадастрын зураг төсвийг тус тус шинээр үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 38.3 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч байгууллага Төрийн банкнаас 2021 онд 25.0 сая төгрөгийн зээлийг өөрийн үйл ажиллагааны зориулалттай авч, зээлийг гэрээний зориулалтын дагуу нүүрс бэлтгэхэд зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 10.0 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 15.0 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг хэрхэн хүлээн зөвшөөрөх талаар тусгагдаагүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, борлуулалт, маркетингийн зардал, хүүгийн зардал, үйл ажиллагааны бусад зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад зардал 33.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт ажиллагсдын цалин, НДШ, хангамжийн материалын зардал, шатахууны зардал, нүүрсний зардал, цахилгааны төлбөр, холбооны зардал, татварууд, албан томиллолт, зээлийн хүүгийн зардал, элэгдлийн

зардлуудыг хамруулсан байна. Үүнээс өртөгт хуваарилагдахгүй зардлууд байхгүй байна. НБББББ-т заасан заалттай нийцэж байна.

### **3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 50 дугаар тушаалаар Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 188.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 186.3 сая төгрөгөөр, 1.8 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хөрөнгө төлөвлөөгүй бөгөөд 2021 онд тодотгол хийгээгүй байна.

Гүйцэтгэлээр 190.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 213.8 сая төгрөгийн зардал гарган, 23.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 190.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 2.2 сая төгрөг буюу 1.16 хувиар давсан нь халуун усны орлого орж голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 213.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 27.5 сая төгрөг буюу 14.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны өр барагдуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 23.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 21.6 сая төгрөгөөр илүү байгаа нь зардал нөлөөлж байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.


### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 26 мэдээллээс 1 төрлийн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 11.7 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.



### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 62.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 75.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар

Гүйцэтгэлийн аудитаар 5.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 471.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн албан бичиг ирүүлсэн байна.

Аудитаар давтан тооцоолоход:

- Хөрөнгийн үлдэгдэлд тооллого хийхэд 3 төрлийн 5.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдаж 2 нэр төрлийн 3 хөрөнгө бүртгэлээс илүүдсэн актыг төсвөөс төлсөн байна.
- "Ажлын байранд зохих зөвшөөрөл авч бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин ажиллуулах" гэсэн шийдвэрийн биелэлтийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 319 тоотор өгөгдсөн албан бичгийн дагуу 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн эсэх, и баримтгүй гүйлгээ хийсэн эсэх, өглөг, авлагыг барагдуулсан эсэх, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн эсэх, зардлын төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан эсэхийг тус тус шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.8 сая төгрөгийн алдааг залруулж, 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 37.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.2.1 Залруулсан алдаа

Тайлант онд 0.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

Тайлант онд 1.7 сая төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан, 7.0 сая төгрөгийн өглөгийг илүү тайлагнасан, орлого үр дүнгийн тайлангийн нийт ашиг алдагдлыг 8.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, мөнгөн гүйлгээний тайланд нийт зардлыг 4.1 сая мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залрууллаа.

### 4.2.2 Төлбөрийн акт

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон 5.0 сая төгрөгийн төлбөрийн актыг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй ажилчдыг амрахад зориулж 334.7 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.2.3 Албан шаардлага


Тайлант онд 5.3 сая төгрөгийн гүйлгээг и баримтгүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

НӨАТ-ын тайланд борлуулалтын орлогыг 0.79 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд НӨАТ-ын өглөгийг 4.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүй, төсөвт 10%-с доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй байгаа нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй 1,000.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-т энэ заасан тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; заалттай



нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын төлөвлөгөөг 25.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж алдагдалтай ажилласан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнгээс 23.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.2. "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### **4.2.4 Зөвлөмж**

Аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Аймгийн засаг даргад**

**1.1 Илрүүлэлт:** Эрдэнэ Эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

**1.1 Өгсөн зөвлөмж:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.1-т "Аймгийн Засаг Дарга нь Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч” ААТҮГ	12	58.1	4	21.4	2	5.3	5	31.4	1	-
<b>Дүн</b>		<b>12</b>	<b>58.1</b>	<b>4</b>	<b>21.4</b>	<b>2</b>	<b>5.3</b>	<b>5</b>	<b>31.4</b>	<b>1</b>	<b>-</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын эрчим хүч” ААТҮГ	2	5.7	1	0.4	-	-	1	5.3		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>5.7</b>	<b>1</b>	<b>0.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>5.3</b>		
<b>Нийт дүн</b>		<b>14</b>	<b>63.8</b>	<b>5</b>	<b>21.8</b>	<b>2</b>	<b>5.3</b>	<b>6</b>	<b>36.7</b>	<b>1</b>	

